

2013 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ ТАЛААРХИ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2013.12.17-ны байдлаар

БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ

Судалгааны код: СТ-13/101

Судалгааны төрөл: Бодлогын судалгаа

Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч

Захиалагч: УИХ-ын гишүүн, ӨБХ-ны дарга Р.Бурмаа,
УИХ-ын гишүүн Х.Болорчулуун

Огноо: 2013.10.08

Сэдвийн агуулга: “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” сэдэвт бодлогын судалгааны бичвэрт газрын тос, байгалийн хийн хайгуул болон олборлолтын үйл ажиллагаанд дэлхий даяар зонхилон хэрэглэдэг бүтээгдэхүүн хуваах гэрээний тухай ерөнхий ойлголт, зардлын тос болон ашгийн тосны хувь хэмжээ, тэдгээрийг засгийн газар, гадаадын нефтийн компанийн хооронд хуваах зарчим, хуваарилалтын бүтэц, роялти хураамж буюу ашигт малтмалын татварын хэмжээ, түүнтэй хослуулан албан татварын хэмжээг уян хатан тогтоосноор гэрээний үр ашигт хэрхэн нөлөөлөхийг шинжилсэн дүн, гэрээний бусад үзүүлэлтүүдийн тухай тайлбар, ашигт малтмалын салбарт хэрэглэдэг гэрээнүүдийн төрөл, тэдгээрийн ялгаа, газрын тос, байгалийн хийнээс бусад салбарт уг гэрээг ашигласан тухай олон улсын туршлагыг тус тус тусгасан болно.

Хайлтын түлхүүр үг: бүтээгдэхүүн хуваах гэрээ, газрын тос, байгалийн хий, түүхий нефть, зардлын тос, ашгийн тос, роялти, ашигт малтмалын татвар, урамшуулал, дотоод борлуулалтын үүрэг, оролцоо

* * * * *

ЛОББИ БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/201
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: П.Амаржаргал, Б.Хатантуул, Б.Цолмонбаяр
Захиалагч: УИХ-ын гишүүн Н.Номтойбаяр
Огноо: 2013.01.21
Сэдвийн агуулга: Судалгаанд АНУ, Англи, Герман, Итали, Канад, Франц, Япон зэрэг нийт 7 улсын хувьд лобби болон сонирхлын бүлгүүдийн хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг харьцуулан, онцлог байдлыг авч үзсэн.

ТЭТГЭВРИЙГ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД НЬ ӨВЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ, ЖУРМЫН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/202
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Товуусүрэн, А.Пагма, Ө.Мөнхтунгалаг, Д.Жигваагүнсэл
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Эрдэнэ
Огноо: 2013.01.22
Сэдвийн агуулга: Уг судалгаагаар Монгол Улсын гэр бүлийн статистик тоо баримтыг Улсын бүртгэлийн газар, Үндэсний статистикийн хорооноос гаргасан баримтат тулгуурлан гаргаж, боловсруулалт хийж, 10-аас дээш жил хамтран тогтвортой амьдарсан нийт гэр бүлийн тоо, бэлбэсэн гэр бүлийн тоог нэгтгэн гаргасан бөгөөд Өндөр насны тэтгэврийг өвлүүлдэг гадаадын улс орнуудын туршлагыг судалснаар тэтгэврийн тогтолцоог шинэчлэх бодлогыг тодорхойлоход анхаарвал зохих асуудлыг тодруулсан болно. Тухайлбал судалгаанд *Чили, Швед, Итали, ОХУ, АНУ, Их Британи зэрэг өндөр хөгжилтэй орнуудыг хамрууллаа.*

ПАРЛАМЕНТЫН ТАНХИМД ГИШҮҮДИЙГ СУУЛГАХ ЭРЭМБЭ ДАРААЛЛЫН ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/203
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Р.Хатанбаатар, Б.Хатантуул
Захиалагч: УИХ-ын Тамгын газрын ЕНБД Б.Болдбаатар
Огноо: 2013.01.07
Сэдвийн агуулга: Уг асуудлын хүрээнд Австрали, Шинэ Зеланд, Энэтхэг, ОХУ, Солонгос, Канад, Сингапур, Финланд, Испани улсуудыг судалсан болно.
Судалгаанаас үзэхэд:

- Австрали, Шинэ Зеланд, Солонгос, Энэтхэг улсын хувьд бол Спикер суудал хуваарилах болон дарааллын асуудлыг шийдвэрлэдэг байна.
- ОХУ хувьд түр ажлын хэсэг байгуулан, гишүүдийг Танхимд суух суудлын дарааллыг тогтоодог байна.
- Норвеги улсын хувьд бол сонгогдсон тойргийнхоо нэрийн цагаан толгойн дарааллаар Танхимд суудаг.
- Канад, Сингапур, Финланд, Испани улсуудын хувьд Парламентын дэгийн тухай хууль болон Парламентын дүрэмдээ нарийвчлан тусгаагүй.

ЦЭНГЭГ НУУРЫН ХАМГААЛАЛТЫН ТАЛААРХИ ГАДААД УЛС ОРНЫ ЭРХЗҮЙН [ЗАРИМ] ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/204
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч, Г.Чулуун
Захиалагч: УИХ-ын гишүүн Г.Баярсайхан
Огноо: 2013.01.22
Сэдвийн агуулга: Цэнгэг нуурын хамгаалалтын талаархи гадаад улс орны эрх зүйн зохицуулалт (АНУ, Канад, ОХУ-ын туршлагаас жишээлсэн лавлагаа)

ГҮНИЙ УСНЫ АШИГЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААДЫН ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/205
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч, Г.Чулуун
Захиалагч: УИХ-ын гишүүн Г.Баярсайхан
Огноо: 2013.01.22
Сэдвийн агуулга: Гүний усны ашиглалт хамгаалалтын эрх зүйн зохицуулалт, гадаадын туршлага (ОХУ, Украин улсын жишээн дээр)

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ШАТАХУУНЫ ЖИЖИГЛЭНГИЙН ҮНЭ, ТҮҮНИЙ БҮТЭЦ

Судалгааны код: СТ-13/206
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Мягмарцэрэн, Ц.Болормаа, Д.Байгалмаа, Г.Гэрэл Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2013.01.23
Сэдвийн агуулга: Судалгаанд нийт 97 оронд борлуулагдаж буй 4 төрлийн шатахууны /АИ-92, АИ-95, АИ-98 болон ДТ/ жижиглэнгийн үнийг 2012 оны эцсийн байдлаар харьцуулан гаргасан. Судалгаанд хамруулсан 97 орноос АНУ, Англи, Япон, Канад, Норвеги, Франц, Итали зэрэг улсуудын жижиглэнгийн үнийн бүтцэд задлан шинжилгээ хийн, жижиглэнгийн үнийн бүрдүүлэлт, түүний бүтцийн ерөнхий зураглалыг гаргасан болно.

ЦЭРГИЙН АЛБА ХААХ ХУГАЦААНЫ ТАЛААРХИ ГАДААДЫН УЛС ОРНЫ ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/207
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Р.Хатанбаатар, Г.Чулуун
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат
Огноо: 2013.01.29
Сэдвийн агуулга: Цэргийн алба хаах хугацааны талаархи гадаадын улс орны эрхзүйн зохицуулалт (ОХУ, АНУ бусад улс орны жишээн дээр хийсэн лавлагаа, харьцуулалт)

ХҮҮХЭД АСАРСНЫ ТЭТГЭМЖ ОЛГОХТОЙ ХОЛБОГДСОН СТАТИСТИК ТОО БАРИМТ, ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Судалгааны код: СТ-13/208
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Товуусүрэн, А.Пагма, Ө.Мөнхтунгалаг, Д.Жигваагүнсэл
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат
Огноо: 2013.02.01

Сэдвийн агуулга: Судалгаанд Монгол улсад Хүүхэд асарсны тэтгэмж олгох талаар шийдвэр гаргахад улсын төсвийн зардалд нөлөөлөх нөлөөллийг статистик тоон мэдээлэл судалгаанд суурилан тооцож гаргасан бөгөөд хүүхэд асарсны тэтгэмжийг хэрхэн ямар хууль эрх зүйн зохицуулалтаар хэрхэн ямар журмаар олгодог тухай гадаадын зарим орны туршлагыг судалсан болно. Тухайлбал судалгаанд Нидерланд, Чех, Узбекистан, ОХУ зэрэг орнуудыг хамруулсан.

АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР (РОЯЛТИ) БА МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛБӨР

Судалгааны код: СТ-13/209
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Мягмарцэрэн, Г.Алтан-Оч, Ц.Болормаа, Д.Байгалмаа, Г.Гэрэл Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2013.02.04
Сэдвийн агуулга: Судалгаанд Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /Роялти/-ийн ерөнхий ангилал, тэдгээрийн давуу болон сул тал, нийт 27 орны ашигт малтмалын төрөл зүйлээс шалгаалсан татварын хувь хэмжээг харьцуулан судалсан. Мөн ашигт малтмалын менежментийн төлбөрийн эдийн засгийн агуулгын ойлголт, түүнийг тооцох суурь тооцоо, Латин Америкийн зарим орнуудын менежментийн төлбөрийн хувь хэмжээний талаарх туршлагыг авч үзсэн.

“ЧИНГИС ХААН” НЭР, “ЧИНГИС ХААНЫ ХӨРӨГ”-ИЙГ ГАДААД УЛСАД ХЭРЭГЛЭХ, АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ”

Судалгааны код: СТ-13/210
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: П.Амаржаргал
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганбат
Огноо: 2013.02.25
Сэдвийн агуулга: Уг судалгаанд хамааруулан Монгол Улсын нэгдэн орсон “Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр” (Madrid Agreement Concerning the International Registration of Marks), “Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийн протокол” (Protocol Relating to the Madrid Agreement Concerning the International Registration of Marks.), “Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенц” (Convention Establishing the World Intellectual Property Organization), “Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц” (Paris Convention for the Protection of Industrial Property) зэрэг олон улсын гэрээ, конвенц, протокол, хэлэлцээрийг авч үзсэн болно.

ӨСӨН НЭМЭГДЭХ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР, ДЭЛХИЙН УЛСУУДЫН ЖИШИГ

Судалгааны код: СТ-13/211
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Мягмарцэрэн, Г.Гэрэл Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
Огноо: 2013.02.25
Сэдвийн агуулга: Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /роялти/-ийн төрөл, хэлбэр түүнээс хамаарсан төлбөрийг ногдуулах арга зам, Ашигт малтмалын нөөц

ашигласны төлбөрийн тогтолцооны давуу ба сул тал, чиг хандлагын талаар судалгаанд авч үзлээ.

Мөн түүнчлэн өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийн хэмжээ, төлбөрийн нөхцөлийн талаар Аргентин, Австрали, Чили, Хятад, Энэтхэг, Перу, Өмнөд Африк зэрэг орнуудыг хамруулан судалсан болно.

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ, ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/212
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Товуусүрэн, Б.Хатантуул
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Оюун, С.Дэмбэрэл
Огноо: 2013.02.28
Сэдвийн агуулга: Энэхүү судалгаагаар Сонгуулийн хуулийн сонгуулийн сурталчилгаа, сонгуулийн сурталчилгааны зардалтай холбоо бүхий 7,8 дугаар бүлгийн заалтуудыг улам боловсронгуй болгоход чиглэгдсэн гадаадын улс орнуудын энэ чиглэлийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлахад оршив. Анли, Канад, Японы Сонгуулийн хуулийн сонгуулийн сурталчилгаа, сонгуулийн сурталчилгааны санхүүжилттэй холбоотой зохицуулалтуудыг судлав.

ЛОГИСТИКИЙН СИСТЕМ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/221
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Билгээ, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Эрдэнэ
Огноо: 2013.06.25
Сэдвийн агуулга: Логистикийн гол асуудал нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, зорилгод нийцүүлэн аливаа түүхий эд, бараа, үйлчилгээ, мэдээлэл, санхүүгийн хөрөнгийг эхлэл цэгээс зорилтот цэг хүртэл хамгийн үр ашигтай шилжүүлэлт ба хадгалалтын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын нэгдмэл процесс юм. Судалгаанд логистикийн систем, хөгжлийн чиг хандлага, түүнчлэн ХБНГУ, ОХУ, БНСУ болон Япон улсын логистикийн эрх зүйн онцлог зохицуулалтыг харьцуулан судалсан.

АРХИНЫ ЭСРЭГ ТЭМЦЛИЙН АРГА ТАКТИК, ДЭЛХИЙН ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13-224
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Чулуун, Д.Батдорж
Захиалагч: УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг
Огноо: 2013.06.11
Сэдвийн агуулга: Архидалттай тэмцэх чиглэлд хүн төрөлтөний олж хуримтлуулсан түүхэн туршлага, газар газрын улс үндэстэнд хэрэгжүүлж ирсэн эрт эдүгээгийн олон “хуурай хууль”-ийн агуулгын онцлогийг тодруулсан харьцуулсан судалгаа юм. (Нийт 17 хууд.)
Архины асуудал бол дан ганц архины асуудал биш юм. Уг судалгаанд,

- Архидан согтуурахын эсрэг улс бүхний өрнүүлсэн, өрнүүлэх бодлого тэмцэл хоорондоо ижилгүй, тийм байх үндэсгүй;
- Архины “нийгмийн аюулыг тэглэх нэгдсэн жор”-ыг өнөө болтол олдоогүй;
- Архины эсрэг үзлийг хүний мөн чанараас салангид авч үзэж, жишээ нь, үндэслэлгүйгээр үнийг нь хэт нэмэх нь нийгмийн ядуу хэсгийг улам ядууруулах аюултай, зөв биш алхам болохыг;

- Уламжлалт заншил ёсыг [зөөлөн, аажмаар] халж журамлах нь нийгмийг архидалтаас ангижруулах үйлсэд дэм өгдөг; ... гэх мэтээр тухайн асуудлыг олон аспектаар баримт жишээтэйгээр харьцуулжээ.

ЗАЛУУ ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ ТӨРИЙН БОДЛОГЫН ТАЛААР БУСАД ОРНЫ ЗОХИЦУУЛАЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ АСУУДАЛ

Судалгааны код: СТ-13/225
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: П.Нарантуяа
Захиалагч: Улсын Их хурлын гишүүн Л.Энх-Амгалан
Огноо: 2013.06.12
Сэдвийн агуулга: Энэхүү судалгаанд АНУ, Их Британи, Франц, Швед, ОХУ, Хятад зэрэг улсуудад “Залуу гэр бүл”-ийг дэмжих талаар гарсан хууль тогтоомж, Төрөөс нь үзүүлж буй бодлого, нийгмийн халамжийн тэтгэмжийн талаархи мэдээллийг цуглуулав. Монгол Улсын төрөөс залуу гэр бүлийн талаар авч явуулж байгаа бодлого түүний үр дүн, статистик үзүүлэлт, судлаачдын гаргасан зөвлөмж, залуучуудын талаар цаашид аль асуудалд илүү анхаарал төвлөрүүлэх шаардлагатай талаар судалгаанд оруулав. Нөгөө талаар Гэр бүл гэсэн нэг цогц ойлголтоор асуудалд хандах нь чухал болохыг судалгааны явцад ажиглагдлаа.

АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ, АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛ БОЛОН АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/226
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг
Захиалагч: УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан
Огноо: 2013.06.18
Сэдвийн агуулга: Уг судалгаагаар бусад улс оронд ажилгүйдлийн тэтгэмж олгодог туршлага, ажилгүйдлийн даатгал болон ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн эрх зүйн зохицуулалтыг харуулахыг зорилоо. Судалгаанд ажилгүйдлийн даатгалын тогтолцоо өндөр хөгжсөн, ажилгүйдлийн тэтгэмж олгох систем нь нэлээд боловсронгуйд тооцогддог Канад, Япон, Чех, Франц зэрэг өндөр хөгжилтэй орнуудын ажил эрхлэлтийн даатгалын тогтолцоо, ажилгүйдлийн тэтгэмж олгох хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг нь харьцуулан судлав.

ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-12/227
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Г.Билгээ, Д.Байгалмаа, Г.Гэрэл, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн, УИХ-ын ТБХ-ны дарга Ц.Даваасүрэн
Огноо: 2013.06.21
Сэдвийн агуулга: Судалгаанд АНУ, ХБНГУ, ОХУ, Япон болон Шинэ Зеланди зэрэг орнуудын төрийн эрх мэдэл хуваарилалт, шүүх эрх мэдлийн байгууллагуудын тогтолцооны онцлог мөн түүнчлэн эдгээр орнуудын төсвийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, парламентаар хэлэлцэн батлах, тайлагнах процессийн талаар судалсан болно.

САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ДАМПУУРЛЫН УЛМААС ҮҮССЭН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХИ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/228
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Байгалмаа, Г.Гэрэл
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Эрдэнэ
Огноо: 2013.06.18
Сэдвийн агуулга: Энэхүү судалгаанд АНУ, Япон улсын банк, санхүүгийн байгууллагын хямрал болон тэдгээрийг дампуурахад Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар, мөн дампуурлаас урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авч байсан талаар судалсан болно. АНУ-ын санхүүгийн байгууллагуудын хямралыг судлахдаа хадгаламж, зээлийн хоршоод болон хадгаламжийн байгууллагуудын хямралын талаар голлон тусгасан. Харин Япон улсын хувьд банк санхүүгийн байгууллагуудын хямралын үед авах арга хэмжээг нийтлэг байдлаар зохицуулсан нь ажиглагдаж байв.

БЭЛЧЭЭРИЙН ТУХАЙ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРОНД ...

Судалгааны код: СТ-13/229
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Чулуун
Захиалагч: УИХ-ын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга
Огноо: 2013.07.10
Сэдвийн агуулга: Судалгаанд, бэлчээрийн зохицуулалтын талаарх хаанахын ямар (улсын) хууль тогтоомжийг сонирхвол илүү өгөөжтэй зохистойг бодолцож, хөрш зэргэлдээ, байгалийн ойролцоо бүс бүслүүр нутагт орших, аль болох бэлчээрийн мал маллагаатай тийм газар орны хууль тогтоомжийг тэргүүн ээлжинд авч үзэхийг чухалчилсан, ө. х., БНХАУ (Өвөрмонголын өөртөө засах орон), Казахстан, Кыргызстан, Тажикстан, Казахстан (хуулийн төсөл), Австралийн бэлчээрийн эрхзүйд холбогдох зохицуулалтуудыг тухайлан авч үзжээ. Бэлчээрийн эрхзүйн талаархи энэ судалгаа дотроо дэд нэр бүхий дэд хэсгүүдтэй, хавсралттай, нийт 17 хууд. юм.

ХҮҮХЭД ҮРЧЛҮҮЛЭХ БОЛОН ХҮҮХЭД ҮРЧЛЭН АВАХ ТАЛААР БУСАД ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/230
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Референт П.Нарантуяа
Захиалагч: УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан
Огноо: 2013.07.08
Сэдвийн агуулга: Хүүхэд үрчлэх тухай асуудал бол маш нарийн зохицуулалт шаардсан хүний эрх, ялангуяа хүүхдийн эрхийг хөндсөн асуудал учраас насанд хүрээгүй хүн өөрийгөө хамгаалах чадваргүй байгааг онцгой авч үзэн хүүхдийн эрхийг дээдлэх зарчмыг асуудлын гол болгон авч үздэг. Судалгаанд Олон улсын конвенц, тунхаглалаас гадна гадаадын 11 улсууд /Франц, БНСУ, Швед, БНХАУ, Бельги, ОХУ, Герман, Япон, Вьетнам, Англи, АНУ/ болон Монгол Улсын хүүхэд үрчлүүлэх болон үрчлэн авах асуудлыг судалж дүгнэлт хийлээ.

НЭМЭГДСЭН ӨРТӨГИЙН АЛБАН ТАТВАР БА ХУДАЛДААНЫ ТАТВАРЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны код: СТ-13/231
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Билгээ, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Г.Энх-Амгалан, Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар
Огноо: 2013.09.19.
Сэдвийн агуулга: Гадаадын зарим орны Нэмэгдсэн өртгийн албан татвар болон Худалдааны татварын хувь хэмжээ, эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулан судалсан болно. Мөн судалгааны явцад Нэмэгдсэн өртгийн албан татвар болон Худалдааны татварын хоорондын ялгаатай ойлголт, онолын тайлбар болон олон улсын чиг хандлагын талаарх асуудлыг хамтатган авч үзэв.

ОЛОН УЛСЫН БА ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/232
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Р.Хатанбаатар, А.Пагма
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Батцогт
Огноо: 2013.09.25.
Сэдвийн агуулга: Олон улсын ба гадаадын зарим орны үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын эрх зүйн зохицуулалт, чиг үүрэг, эрх хэмжээ, бүтэц зохин байгуулалтын талаар болон энэ асуудлаар дэлхийн болон бүс нутгийн олон улсын байгууллагын зөвлөмж, тайлан, судалгааны материалын жагсаалтыг бэлтгэв.

ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/233
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Байгалмаа, Ц.Элбэгзаяа
Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Бямбацогт
Огноо: 2013.09.30
Сэдвийн агуулга: Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу үйлдвэржүүлэлттэй холбоотой доорх асуудлын хүрээнд энэхүү судалгааг гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Үйлдвэржүүлэлтийн бодлогын асуудлууд
 - Үйлдвэржүүлэлтийн бодлогын стратеги
 - Үйлдвэржүүлэлтийн бодлогын хэрэгслүүд /АНУ, Герман, Франц, Японы жишээн дээр/
 - Үйлдвэрлэлийн ангилал /жижиг, дунд, том үйлдвэр гэсэн ойлголтыг ямар хүрээнд тодорхойлдог болох/
 - Аж үйлдвэржсэн орнуудын эдийн засгийн шалгуур үзүүлэлт
- Үйлдвэржүүлэлтийн бодлого, төлөвшлийн түүхэн замнал, өнөөгийн үйлдвэрлэл
- Гадаадын зарим улс орнуудын үйлдвэржүүлэлтийн туршлагаас /Чех, Польш, Солонгос, Тайвань, Сингапур/

ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НИЙГМИЙН ХЭВ ЖУРМЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/234
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Р.Хатанбаатар, А.Пагма
Захиалагч: УИХ-ын гишүүн Ж.Батзандан

Огноо: 2013.10.03
Сэдвийн агуулга: Нийгмийн тогтсон хэм хэмжээний эсрэг үйлдлийн эрх зүйн зохицуулалтыг Их Британи, Латви, Украин улс, олон нийтийн аюулгүй байдлын талаарх эрх зүйн зохицуулалтыг АНУ, ОХУ-ын жишээн дээр харьцуулан авч үзсэн ба ХБНГУ, АНУ зэрэг олон улсад олон нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангахад иргэдийн оролцоог чухалчлан үзэж зарим улсад хууль, эрх зүйн актаар баталгаажуулдаг талаар мэдээллийг бэлтгэв.

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ЦАЛИН ХӨЛС, ХАНГАМЖИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны код: СТ-13/235
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Ц.Болормаа
Захиалагч: Захиргаа, нийтлэг үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн дарга Б.Цэвээнпүрэв
Огноо: 2013.10.10.
Сэдвийн агуулга: Тус судалгаанд Австрали, ОХУ, Энэтхэг, Шинэ Зеланд, АНУ, Их Британи, Канад, Финланд, Грек, Япон зэрэг улс оронд Парламентын гишүүнд хууль тогтоох, төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлсэнийх нь төлөө олгож буй цалин бусад хангамжийг ямар эрх зүйн орчны хүрээнд ямар хэмжээгээр хэрхэн тогтоож байгаа талаар харьцуулан судалсан болно.

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛД ХАМААРАЛ БҮХИЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН УЯЛДААГ ХАНГАХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ “СУБЪЕКТ”

Судалгааны код: СТ-13/236
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Чулуун
Захиалагч: УИХ-ын гишүүн М.Батчимэг
Огноо: 2013.10.14.
Сэдвийн агуулга: Монголын нийгмийн хотжиж процесс “дур зоргоор, нялх, туршлагагүй”, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стратегийн зохицуулалт сул байгаагийн улмаас улсын нийслэлийн замын нэвтрүүлэх чадамж буурч осол зөрчил ихэсч байна. Замын түгжрэл нь замын нэвтрүүлэх чадамжийн дам илэрхийлэл байдаг. Нэвтрүүлэх чадамжийн үзүүлэлт нь эргээд замын хөдөлгөөний аюулгүй байдлын нэг ёсны итгэлцүүр болдог.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын асуудалд хамаарал бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нэгдмэл уялдааг гадаадын улс оронд хэрхэн хангадаг; талаарх сэдэвчилсэн товч мэдээлэл, ОХУ, БНХАУ болон гадаадын бусад орны эрх зүйн зохицуулалтын жишээнд түшиглэсэн лавлагаа юм. (Нийт 7 хууд.)

Лавлагаанд, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хуулийн дагуу үүрэг хүлээсэн төрийн болон бусад байгууллагуудын ажлын нэгдмэл уялдааг гадаадын улс орнуудад нутгийн захиргааны байгууллага хангадаг – ийг жишээ баримттай дурдаад саналын чанартай доорх санааг тусгажээ. Үүнд:

- Замын хүртээмж буурахад нөлөөлдөг хүчин зүйлсийн хүрээг зөв зөв тодорхойлох;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дотор нь стратеги ба тактикийн чиг баримжаагаар зааглаж, алсыг харсан бүтээн байгуулалтын чанартай ажилбаруудыг зам дээр явагддаг өдөр тутмын урсгал зохицуулалтаас салгаж авч үзэх;

- Яам хоорондын ажил асуудлыг хамтарсан тушаалаар зохицуулчихаж болдог бол олон газрын хамааралт үйл ажиллагааг талуудын эрхийн тэнцвэр дээр нэгтгэн зохицуулах бололцоо харьцангуй бага, завсарт нь ажил эзэнгүйдэн орхигддог тул, замын хөдөлгөөний стратеги зохицуулалтыг дагнан хариуцдаг, удирдан зангидах, уялдуулан зохицуулах үүрэг бүхий захиргааны бүтэц бий болгох;

Олон салбар дундын онцлог чанараасаа болоод хууль тогтоомжоор тэр бүр тодорхой сайн эзэнжиж өгдөггүй, сугараад үлдчихдэг, хаягдчихдаг, сайн саар дагавар нь нийгэмд шууд мэдрэгддэг “замын хөдөлгөөний стратеги зохицуулалт” –ын бүлэг ажил “багц хуульгүй, барьж хөөцөлдөх эзэн-байгууллагагүй” явж ирсэн гэсэн санааг ч мэдээлэлд мөн тусгажээ.

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ГАЗРЫН ТОСНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

<i>Судалгааны код:</i>	СТ-13/237
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Билгээ, Ч.Онончимэг
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн, ЭЗБХ-ны дарга Б.Гарамгайбаатар
<i>Огноо:</i>	2013.10.16
<i>Сэдвийн агуулга:</i>	Судалгаанд газрын тосны олон улсын хууль тогтоомжийн ангилал, хамрах хүрээ, гадаадын зарим орны газрын тосны эрх зүйн зохицуулалт /Норвеги, Казахстан, Орос/, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ /газрын тос, байгалийн хийн хайгуул болон олборлолтын үйл ажиллагаанд дэлхий даяар зонхилон хэрэглэдэг бүтээгдэхүүн хуваах гэрээний тухай ерөнхий ойлголт, зардлын тос болон ашгийн тосны хувь хэмжээ, тэдгээрийг засгийн газар, гадаадын нефтийн компанийн хооронд хуваах зарчим, хуваарилалтын бүтэц, роялти хураамж буюу ашигт малтмалын татварын хэмжээ, түүнтэй хослуулан албан татварын хэмжээг уян хатан тогтоосноор гэрээний үр ашигт хэрхэн нөлөөлөхийг шинжилсэн дүн, гэрээний бусад үзүүлэлтүүдийн тухай тайлбар, ашигт малтмалын салбарт хэрэглэдэг гэрээнүүдийн төрөл, тэдгээрийн ялгаа, газрын тос, байгалийн хийнээс бусад салбарт уг гэрээг ашигласан тухай олон улсын туршлага/-г тус тус тусгасан болно.

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ, ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

<i>Судалгааны код:</i>	СТ-13/238
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Д.Жигваагүнсэл, Ц.Болормаа, Г.Билгээ
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат, Л.Болд
<i>Огноо:</i>	2013.10.31
<i>Сэдвийн агуулга:</i>	Судалгаанд эдийн засгийн чөлөөт бүсийг амжилттай хөгжүүлж байгаа болон хөгжлийн түвшингээр манай улстай ойролцоо зэрэг зарим нөхцөл байдлыг харгалзан ОХУ, БНКазахстан Улс, БНБеларус Улс, БНСерби Улс, Доминиканы БНУ, БНХАУ, БНСУ, БНТурк Улс, Тайвань, Малайзын Холбооны Улс зэрэг 10 орныг сонгон авч холбогдох хууль эрх зүйн орчинг харьцуулан судлав. Мөн Монгол Улсын чөлөөт бүсийн эрх зүйн орчны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийв.

ДЭЛХИЙД ХӨГЖЛӨӨРӨӨ ТЭРГҮҮЛЭГЧ ЗАРИМ ОРНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН АРГА, ТУРШЛАГА

<i>Судалгааны код:</i>	СТ-13/239
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Б.Байгалмаа, Г.Билгээ, Ц.Элбэгзаяа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн С.Бямбацогт
<i>Огноо:</i>	2013.11.15
<i>Сэдвийн агуулга:</i>	Дэлхий дахинд хөгжлөөрөө тэргүүлэгч, хөгжлийн тогтвортой, тодорхой бодлого хэрэгжүүлдэг зарим орнуудын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн онцлог, арга туршлага болон бодлого боловсруулахад баримталдаг зарчим, бодлогын хоорондын уялдаа холбоо, амжилтанд хүрсэн туршлага, ирээдүйн хөгжлийн төлөвлөлт болон төсөөллийн талаарх асуудлыг хамруулсан. Судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу Швейцарь, Их Британи, Япон, Өмнөд Солонгос, Хятад, Орос, Малайз улсуудын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн туршлагыг судалсан болно.

АМАРЖСАН ЭХЧҮҮДЭД ҮЗҮҮЛДЭГ НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ГАЗРЫН ТОСНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

<i>Судалгааны код:</i>	СТ-13/240
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Р.Хатанбаатар, А.Пагма, Ө.Мөнхтунгалаг
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл
<i>Огноо:</i>	2013.12.06
<i>Сэдвийн агуулга:</i>	Гэр бүлийн талаар баримтлах бодлогын нэг чухал хэсэг болох жирэмсэн эмэгтэйчүүд, амаржсан эх, нялхсыг хамгаалах, тэтгэмж, тусламж үзүүлэх, хүүхэдтэй гэр бүлд хөнгөлөлт үзүүлэх халамж, үйлчилгээний талаар гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт, туршлагын талаар мэдээллийг бэлтгэв.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ПРАКТИКТ “ГЕНИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГ” АШИГЛАЖ ГЭМТ ХЭРГИЙГ ИЛРҮҮЛЖ БУЙ ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

<i>Судалгааны код:</i>	СТ-13/241
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Ш.Түвдэндорж
<i>Огноо:</i>	2013.12.10
<i>Сэдвийн агуулга:</i>	Энэхүү судалгаа нь Шүүхийн шинжилгээний практикт генетик мэдээллийн сан бүрдүүлэн ашиглаж буй гадаадын улс орнуудын туршлага, хууль эрх зүйн орчныг судалж, бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд анхаарвал зохих асуудлуудыг тодруулахад чиглэгдсэн.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

<i>Судалгааны код:</i>	СТ-13/242
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Норовдондог (доктор), Г.Алтан-Оч (доктор), Д.Байгалмаа (магистр), Г.Билгээ (магистр), Ц.Болормаа (магистр), Ч.Онончимэг (магистр), Ц.Элбэгзаяа (магистрант)

Захиалагч:
Огноо:
Сэдвийн агуулга:

УИХ-ын гишүүн С.Эрдэнэ
2013.12.12

Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийн холбогдолтой практикт зөрчил үүсгэж буй тодорхой асуудлуудыг бусад орнуудын хууль тогтоомжоор хэрхэн зохицуулсан, олон улсад баримталдаг зохицуулалтын нийтлэг стандарт нь ямар байдаг, судлаачид, мэргэжлийн хүмүүс хэрхэн үзэж байгаа талаар судалгааны мэдээллийн хайлт хийж, олдсон мэдээллийн хүрээнд асуудлыг тодруулан гаргах, захиалагчид тодорхой мэдлэг, ойлголт өгөхөд чиглэгдсэн болно. Судалгаанд:

- Олон улсын хөгжлийн агентлаг (OECD)-аас баталсан “Компанийн засаглалын зохицуулалтын олон улсын зарчим ба хэрэгжүүлэх механизм”
- Үнэт цаасны зохицуулах байгууллагуудын холбоо (IOSCO)-ноос баталсан “Үнэт цаасны зохицуулалтын зорилго ба зарчим, хэрэгжүүлэх механизм”
- Бусад орнуудын Хувьцаат компанийн үйл ажиллагааг зохицуулсан хууль эрх зүйн актуудыг судалж, олдсон мэдээллийн хүрээнд хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, тэдгээрийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой асуудлуудыг тодруулан гаргах (АНУ, Англи, ОХУ, Турк, Герман улс).

* * * * *

МОНГОЛЧУУДЫН БЭЛЧЭЭР АШИГЛАЛЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, БЭЛЧЭЭРИЙН .. ХУУЛИЙН ТӨСӨЛД ХОЛБОГДОХ ЗАРИМ ХИЙСВЭР АСУУДАЛ

Судалгааны код: СТ-13/301

Судалгааны төрөл: Тойм судалгаа

Гүйцэтгэсэн судлаач: Г.Чулуун

Захиалагч: УИХ-ын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга

Огноо: 2013.06.20

Сэдвийн агуулга: Монголд газар өмчлөлийн .. хууль гараад багагүй хугацаа өнгөрчээ. Гэсэн ч нийслэл .. суурин газарт хүртэл газар өмчилсөн хүний тоо өнөөг хүртэл чамлалттай хэвээр байгаа. Малын бэлчээрийг малчдад эзэмшүүлэх, өвөлжөөг өмчлүүлэх асуудал нь шийдвэр гаргах дээд түвшинд энэ хугацаанд хэдэнтээ сөхөгдсөн ч хуульчлагдаагүй юм. Хөдөөний малчид ядаж өвөлжөөний газраа ч болов өөрийн болгоод авчих сонирхолтой байдаг ч судалгаа тандалтаар бэлчээрийг дундын эзэмшил хэлбэрээр үнэгүй ашиглах уламжлалт арга (сонирхол) давамгайлсаар явж ирэв. Бэлчээрий маргаан гэж нэг “байнгын зовлон” бас бий. Тиймээс, малын бэлчээрийг эзэмшиж ашиглаж ирсэн монгол түмний уламжлалт арга ухаан ямар байсан, яаж өөрчлөгдөж “хөгжиж” ирснийг энэ судалгаа (нийт 17 хууд. мат.)-нд олон талаас нь харж нэгтгэн тоймложээ.

* * * * *

БНСУ-ЫН ҮНДЭСНИЙ АССАМБЛЕЙН АЖЛЫН АЛБАДЫН ТУХАЙ

Судалгааны код: СТ-13/401

Судалгааны төрөл: Лавлагаа, мэдээлэл

Гүйцэтгэсэн судлаач: Р.Хатанбаатар, Ц.Товуусүрэн, А.Пагма

Захиалагч: УИХ-ын Тамгын газрын ЕНБД Б.Болдбаатар

Огноо: 2013.01.07

Сэдвийн агуулга: БНСУ-ын Үндэсний Ассамблейн Ажлын албадын үйл ажиллагааны талаар лавлагааг бэлтгэхдээ Үндэсний Ассамблейн Тамгын газар, Номын сан, Төсвийн шинжилгээний алба, Судалгааны албадын бүтэц, үйл ажиллагаа, ажлын онцлог, туршлагыг тусган, бүтэц, үйл ажиллагааны бүдүүвч зэргийг харуулан уг мэдээллийг бэлтгэсэн.

ПАРЛАМЕНТ ДАХЬ НАМЫН БҮЛГҮҮДИЙГ ЧУУЛГАНЫ ИРЦ БҮРДҮҮЛЭЭГҮЙ ШАЛТГААНААР ТАРААХ ҮНДЭСЛЭЛ БИЙ ЭСЭХ ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/402

Судалгааны төрөл: Лавлагаа, мэдээлэл

Гүйцэтгэсэн судлаач: Р.Хатанбаатар, Б.Хатантуул

Захиалагч: УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга А.Бакей

Огноо: 2013.01.30

Сэдвийн агуулга: Уг асуудлын хүрээнд Казахстан, Узбекистан, Молдова, Киргиз, Армен, Шинэ Зеланд, Испани, Аргентин, ОХУ, Франц, Серб улсуудыг судалсан болно.

- Казахстан, Узбекистан, Молдова, Киргиз, Армен, Шинэ Зеланд, Испани улсуудын хувьд бүлгийн гишүүдийн тоо нь бүлгийг бүртгэх тоонд хүрэхгүй болсон тохиолдолд бүлэг үйл ажиллагааг зогсоодог.
- Узбекистан, Киргиз улсын хувьд мөн түүнчлэн өөрийн санаачлагаар эсвэл хууль тогтоох танхимын бүрэн эрхийн хугацаа дууссан үед бүлгийн үйл ажиллагаа зогсдог.
- Аргентин Улсын Депутатуудын Танхимын дүрэм, Үндэсний Конгрессын Акт, ОХУ-н Төрийн Думын Регламент, Францын Үндэсний Ассамблейн

хуралдааны дэг, Сербийн Үндэсний ассамблейн дэг болон Үндэсний ассамблейн хуульд намын бүлгийг тараах асуудлаар нарийвчлан тусгаагүй байна.

ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН АГУУЛГАД ХОЛБОГДОХ ЗАРИМ ЛАВЛАГАА

<i>Судалгааны код:</i>	СТ-13/403
<i>Судалгааны төрөл:</i>	Лавлагаа, мэдээлэл
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Р.Хатанбаатар, Г.Чулуун
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат
<i>Огноо:</i>	2013.02.04
<i>Сэдвийн агуулга:</i>	Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн тухайлсан зарим заалт, тэдгээрийн [хүлээгдэж байгаа] өөрчлөлтийн талаар лавлагаа тодруулга хийв. Үүнд: 1) Монгол Улсад цэргийн алба хаах хугацааг өөрчилж байсан шалтгаан нөхцөл; 2) Цэргийн алба хаах хугацааг 24 сар болгон өөрчилж хуульчилсан тохиолдолд, уг шийдлээс, улсын нийгэм эдийн засгийн байдалд үзүүлэх нөлөөлөл 3) Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн 5-р зүйлийн 5.2.7-д дурдсан “цэргийн албан хаагч бүр цэргийн мэргэжилд заавал сурах”-д [өнөөгийн] 12 сарын хугацаа хүрэлцээтэй эсэх; 4) Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь заалт -ыг хүчингүй [болсоноос] үүсэх үр нөлөө; 5) Цэргийн дүйцүүлэх алба хаагчдын тоо; /сүүлийн 5 жилийн байдлаар/ 6) Гадаадын улс орнууд дахь цэргийн алба хаах хугацааны талаархи зохицуулалт, харьцуулалт;

НИЙТИЙН АЛБАНД АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР

<i>Судалгааны код:</i>	СТ-13/404
<i>Судалгааны төрөл:</i>	Лавлагаа, мэдээлэл
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Р.Хатанбаатар
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Ж.Батзандан
<i>Огноо:</i>	2013.02.04
<i>Сэдвийн агуулга:</i>	Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх гадаадын зарим улс орны туршлага

ДЭЛХИЙН ЗАРИМ УЛС ОРНЫ ХИЛИЙН БООМТЫН АСУУДАЛ ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГУУД, ТЭДГЭЭРИЙН ХАРЪАЛАЛ

<i>Судалгааны код:</i>	СТ-13/405
<i>Судалгааны төрөл:</i>	Лавлагаа, мэдээлэл
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Товуусүрэн, Ө.Мөнхтунгалаг
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн М.Батчимэг
<i>Огноо:</i>	2013.02.15
<i>Сэдвийн агуулга:</i>	Дэлхийн зарим улс орны хилийн боомтын асуудал эрхлэх байгууллагууд, тэдгээрийн харьяаллын талаар судалсан.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЗАМЫН ЗУРАГЛАЛ

Судалгааны код: СТ-13/410
Судалгааны төрөл: Лавлагаа, мэдээлэл
Гүйцэтгэсэн судлаач: Р.Хатанбаатар, А.Пагма, Р.Оргилмаа
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл
Огноо: 2013.06.03
Сэдвийн агуулга: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль, эрх зүйн актуудын дагуу зохион байгуулж байгаа байдлын танилцуулга, “замын зураглал” болон бодит байдал дээр Засгийн газрын худалдан авах ажиллагаа хэрэгжиж байгаа байдлын жишээн дээр уг мэдээлэл, лавлагааг бэлтгэсэн.

МОНГОЛ УЛС ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЭРХ ЗҮЙН АКТУУДЫН ХЭРЭГЖИЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ АВЛИГАТАЙ ТЭМЦЭЖ БУЙ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/411
Судалгааны төрөл: Лавлагаа, мэдээлэл
Гүйцэтгэсэн судлаач: Ө.Мөнхтунгалаг
Захиалагч: УИХ-ын гишүүн С.Эрдэнэ
Огноо: 2013.06.25
Сэдвийн агуулга: Судалгаанд Монгол Улс дахь авлигын нөхцөл байдлыг олон улсын байгууллагуудын үнэлгээ болон үндэсний хэмжээнд хийгдсэн судалгааны үр дүнд үндэслэн тодорхойлж, авлигатай тэмцэх эрх зүйн актуудын хэрэгжилтийн талаарх статистик мэдээлэл, авлигын олон улсын нөхцөл байдал, бусад орны авлигатай тэмцэх эрх зүйн орчны хүрээнд холбогдох олон улсын байгууллага, мэргэжлийн байгууллага болон Тамгын газрын судлаачдын өмнө нь хийсэн судалгааны мэдээллийг тойм хэлбэрээр бэлтгэсэн болно.

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ИЖИЛ ХҮЙСТНИЙ ГЭРЛЭЛТИЙН ЭРХ ЗҮЙН СТАТУС, ИЖИЛ ХҮЙСТЭН ХОСУУДЫН ХҮҮХЭД ҮРЧИЛЖ АВАХ АСУУДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА

Судалгааны код: СТ-13/413
Судалгааны төрөл: Лавлагаа, мэдээлэл
Гүйцэтгэсэн судлаач: А.Пагма
Захиалагч: УИХ-ын гишүүн Ж.Батзандан
Огноо: 2013.06.28
Сэдвийн агуулга: Гадаадын 39 орны ижил хүйстний гэрлэлт, ижил хүйстний бусад харилцааны эрх зүйн статус, хууль тогтоомжоор тэдэнд олгогдсон эрхийн лавлагааг гарган, ижил хүйстэн хосуудын хүүхэд үрчилж авах асуудлын эрх зүйн зохицуулалт, энэ асуудлаарх зарим статистик тоо баримтын талаар энэхүү мэдээлэл, лавлагааг бэлтгэв.

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН БУЦААН ОЛГОЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/414
Судалгааны төрөл: Лавлагаа, мэдээлэл
Гүйцэтгэсэн судлаач: Г.Билгээ, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Ж.Батзандан
Огноо: 2013.07.08
Сэдвийн агуулга: Судалгаанд Их Британи, Нидерланд, ОХУ, Украин, болон БНХАУ-ын Хүн амын орлогын албан татварын эрх зүйн зохицуулалт, албан татварын хувь,

хэмжээ болон татварын буцаан олголтын тогтолцоо, зохицуулалтын талаар авч үзсэн болно.

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН БУЦААН ОЛГОЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/415
Судалгааны төрөл: Лавлагаа, мэдээлэл
Гүйцэтгэсэн судлаач: Г.Билгээ, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Ж.Батзандан
Огноо: 2013.07.08
Сэдвийн агуулга: Судалгаанд Индонези, Казахстан, Нидерланд, ОХУ, Чили болон БНХАУ-ын НӨАТ-ын эрх зүйн зохицуулалт, албан татварын хувь, хэмжээ болон НӨАТ-ын буцаан олголтын эрх зүйн зохицуулалтын талаар авч үзсэн болно.

ЛОГИСТИКИЙН СҮЛЖЭЭНИЙ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/416
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Билгээ, Ч.Онончимэг
Захиалагч: УИХ-ын гишүүн Г.Батхүү
Огноо: 2013.07.30.
Сэдвийн агуулга: Монгол Улсын хууль тогтоомжид тээвэр, нефть, хийн хоолой, холбооны болон цахилгааны дулаан дамжуулах шугам, бараа бүтээгдэхүүний агуулах, тээврийн нэгдсэн логистикийн сүлжээний асуудлыг Олон Улсын гэрээ, конвеци, Монгол Улсын хууль тогтоомжийн гол заалт, зохицуулалтын эрх зүйн мэдээллийг оруулсан.

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, БҮС НУТГУУДАД ХУВААХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/417
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг
Захиалагч: УИХ-ын гишүүн Г.Энх-Амгалан, Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар
Огноо: 2013.09.23.
Сэдвийн агуулга: Судалгаанд дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж ирсэн бүсчилсэн хөгжлийн бодлогын арга, зохицуулалт, бүс нутгуудад хуваах шалгуур үзүүлэлт, бүсчилсэн хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж ирсэн арга, төрийн зохицуулалтын асуудлууд, бүс нутгийн хөгжлийг дэмжих институцийг бүрдүүлэх асуудлуудыг тусгасан болно.

ГАДААДЫН УЛС ОРНЫ “ЖОЛООЧ БЭЛТГЭХ АРГА ТОГТОЛЦОО, ЖОЛООНЫ ШАЛГАЛТ АВАХ, ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЭРХ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА” –ЫН ТАЛААРХ ЗАРИМ ЛАВЛАГАА

Судалгааны код: СТ-13/418
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Г.Чулуун
Захиалагч: УИХ-ын гишүүн М.Батчимэг
Огноо: 2013.09.30
Сэдвийн агуулга: Лавлагаанд, [ОХУ, БНХАУ, ХБНГУ, АНУ .. зэрэг] гадаадын улс орнуудад “тээврийн хэрэгслэлийн жолоочийн шалгалт авах, жолооны үнэмлэх олгох

ажлыг [тэндэхийн] ямар байгууллага эрхлэн хариуцдаг ..” –ийг энд жишээлэн тодруулжээ.

Жолоодох эрхийн үнэмлэхийг авах олгох асуудал заавал “шалгалт өгөх”, шалгжжр давах зарчмын үндсэн дээр шийдэгддэг нь дэлхийн аль ч улс оронд нийтлэг; гэж үзэж болохоор байна. Харин, жолооны шалгалтад хүнийг бэлдэх (бэлтгүүлэх), шалгалтыг хаанаас яаж авах нь улс орон бүрт тэр бүр харилцан адилгүй юм. Лавлагааны агуулгад зарим санаа санал туссан. Үүнд:

- Монголд “жолоочийн пермит эрх” үгүй тул, манай Автотээрийн тухай хуулийн агуулга дахь “мэргэшсэн жолооч” ухагдахууныг дахин тодорхойлох шаардлагатай;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн засаг төрийн бодлогын тодорхойлогч нэг чухал хүчин зүйл нь “жолооч бэлтгэх үйл явцад [дээрээс] тавих хатуу чанд хяналт мөн” гэсэн үзэл хандлагыг өөрчлөх;
- Олон улс орон иргэндээ “жолооны эрх” –ийг нь өгөхгүйн төлөө биш, чухамхүү өгөхийн төлөө .. асуудалд уян хатан, ө. х. зохион байгуулалтын хариуцлагатай бөгөөд шударга [аль болох авилгагүй, аядуу зөөлөн, захиргаадалтын биш] арга тактик баримталдаг; .. г. м.

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨХ САРЫН ОРЛОГЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ ТОГТООХТОЙ ХОЛБОГДСОН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/419
Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа
Гүйцэтгэсэн судлаач: Р.Хатанбаатар, А.Пагма
Захиалагч: УИХ-ын гишүүн Р.Бурмаа
Огноо: 2013.10.08
Сэдвийн агуулга:

Нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын орлогын дээд хэмжээг тогтоохтой холбогдсон хууль, эрх зүйн зохицуулалт, сарын орлого, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ, нийгмийн даатгалын суурь үнэ, түүнийг тогтоодог байгууллагын талаар Швед, Норвеги, Их Британи, Австри, ОХУ-ын жишээн дээр мэдээллийг бэлтгэв.

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ОЛОН НИЙТИЙН ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГАД ХЯНАЛТ ТАВИХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/420
Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа
Гүйцэтгэсэн судлаач: Ө.Мөнхтунгалаг
Захиалагч: УИХ-ын даргын зөвлөх З.Нарантуяа
Огноо: 2013.10.09
Сэдвийн агуулга:

Монгол Улсын олон нийтийн телевизийн сувгуудаар бусад орны соёл, зан заншил, ёс суртахууныг харуулсан олон ангит киног байнгын давтамжтайгаар гаргаж байгаань хүүхэд залуучуудын оюун санаа, зан суртахуунд нөлөөлж байна гэсэн шүүмжүүд олон нийтийн дунд түгээмэл байдаг тул бусад орнуудын олон нийтийн телевизүүд гадаадын кино, нэвтрүүлгийн эфирийн цагт эзлэх хувь хэмжээг хуульчлан тогтоодог эсэх, хэрвээ тогтоодог бол ямар хяналт, зохицуулалттайгаар энэ асуудлыг шийдвэрлэдэг талаарх туршлагыг харьцуулан судалсан.

АНУ-Д АЖИЛЛАЖ АМЬДАРЧ БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД ТУХАЙН УЛСЫН НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА

Судалгааны код: СТ-13/421

Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа

Гүйцэтгэсэн судлаач: Р.Хатанбаатар, А.Пагма

Захиалагч: УИХ-ын гишүүн С.Эрдэнэ

Огноо: 2013.10.15

Сэдвийн агуулга: АНУ-ын татварын тогтолцоо, нийгмийн ба эрүүл мэндийн даатгалын талаар болон мөн АНУ-д албан ёсоор ажиллаж, амьдарч, сурч байгаа бүх хүн, түүний дотор гадаадын иргэд ч ажил хийхдээ Social Security Number (SSN) буюу нийгмийн даатгалын дугаар авсан байх ёстой бөгөөд энэ нь тухайн хүн хууль ёсны үндсэн дээр ажиллаж байгаагийн баталгаа болж, ажил олгогчоос ажиллагсдын хөдөлмөрийн хөлснөөс татвар суутгахад хэрэглэгддэг талаар мэдээлэл бэлтгэсэн.

ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Судалгааны код: СТ-13/422

Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа

Гүйцэтгэсэн судлаач: Р.Оргилмаа

Захиалагч: УИХ-ын гишүүн, ӨБХ-ны дарга Р.Бурмаа

Огноо: 2013.10.15

Сэдвийн агуулга: Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хууль эрх зүйн орчинг сайжруулахад Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Канад улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Оросын Холбооны Улс зэрэг бусад орны туршлагын талаар мэдээлэл лавлагааг хийж гүйцэтгэв.

ОХУ-ЫН ТЭТГЭВЭР, НИЙГМИЙН ДААТГАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЧИГ ҮҮРЭГ, ЭРХ ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны код: СТ-13/423

Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа

Гүйцэтгэсэн судлаач: Р.Хатанбаатар, А.Пагма

Захиалагч: УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ

Огноо: 2013.11.25

Сэдвийн агуулга: Гэр бүлийн талаар баримтлах бодлогын нэг чухал хэсэг болох жирэмсэн эмэгтэйчүүд, амаржсан эх, нялхсыг хамгаалах, тэтгэмж, тусламж үзүүлэх, хүүхэдтэй гэр бүлд хөнгөлөлт үзүүлэх халамж, үйлчилгээний талаар гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт, туршлагын талаар мэдээллийг бэлтгэв.

ЭХ НЯЛХАСЫН ХАЛАМЖИЙН АГУУЛГАТАЙ [МАНАЙ] ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Судалгааны код: СТ-13/424

Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа

Гүйцэтгэсэн судлаач: Г.Чулуун

Захиалагч: УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл

Огноо: 2013.12.10

Сэдвийн агуулга: Нийгмийн халамж нь хүн амын эмзэг хэсэгт хамаарах .. эх, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, нэн ядуу амьдралтай иргэнд тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тэдний амжиргааг дээшлүүлэх, түүчлэн хүүхэд төрүүлсэн эх, бүтэн өнчин хүүхэд үрчлэж авсан гэр бүл, ихэр

хүүхдэд тэтгэмж олгох [улсаас харж үзэх] нийгмийн хамгааллын арга хэмжээ юм.

Амаржсан эхийн тэтгэмж нь эхийн урамшууллын хүрээнд хөндөгддөг бүлэг асуудлын нэг төрөл, явцуу агуулгатай сэдэв юм. Захиалагчийн¹ хүсэлтэд “амаржсан эхчүүдэд үзүүлж ирсэн халамж хангамж, тэтгэмж тусламж” –ийн талаар тухайлж заасан учраас, асуудлыг бид “амаржсан эх” ухагдахууны хамаарах тэр зурвас хугацаанд хэрэгжих арга хэмжээгээр хязгаарлахыг эрмэлзэв. “Амаржсан эх” ойлголтын хүрээнд хамаарах хугацаа хэзээ эхэлдэг нь тодорхой ч хэзээ дуусдаг нь зарим талаар маргаантай байна.

Хууль тогтоомжийн агуулга дахь “жирэмсэн эх”, “амаржсан эх” нэр томъёо хоорондоо мэдээж утгын ялгамжтай ч, нийлээд, тухайн эхийн үрээ тээж төрүүлэх, хөхүүлж торниулах бүтэн циклийн хугацааг дам илэрхийлж, “жирэмсэн, хөхүүл эх, нярайн” гэсэн агуулга тодотголтой нийгмийн хамгааллын бусад арга хэмжээтэй цаг хугацааны хувьд үндсэндээ давхцдаг. Тиймээс нөхөн үржихүйн давтамжит циклийн .. мөчлөгт хамаарах тэтгэмж тусламжийн талаар; гэх маягаар асуултыг өргөтөн ярих хэрэгцээ заримдаа гардаг. Лавлагаанд, эх нялхаст анхаарал халамж тавьж ирсэн [монголын] нийгмийн түүх уламжлалын болон өнөөгийн бодит байдлын талаарх мэдээллийг оруулав.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИНГЭЭХ ЧАДВАР, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Судалгааны код: СТ-13/425

Судалгааны төрөл: Мэдээлэл лавлагаа

Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч, Ц.Элбэгзаяа

Захиалагч: УИХ-ын гишүүн С.Ганбаатар

Огноо: 2013.11.29

Сэдвийн агуулга: Уг лавлагаа мэдээллийн судалгааны бичвэрт “шингээх чадвар” гэж чухам юуг хэлдэг, тухайн асуудалтай холбогдох судалгааны бусад чиглэлүүд юу болох, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шингээх чадварыг тодорхойлох, түүнд нөлөөлөх хүчин зүйлс юу болох, Монгол Улсын төсвийн болон гадаадын хөрөнгө оруулалтын шингээх чадварыг хэрхэн тодорхойлсоныг тоймлон товчилж тусгасан болно.

Хайлтын түлхүүр үг: шингээх чадвар, аж ахуйн нэгжийн шингээх чадвар, хөрөнгө оруулалтын шингээх чадвар, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шингээх чадвар, хүний нөөцийн баялаг, санхүүгийн зах зээлийн тогтолцоо, технологи нэвтрүүлэлт, технологийн болон байгууллын түвшин

* * * * *

¹ УИХ –ын гишүүн С. Дэмбэрэл, 2013.11.19 –ний №8/7324 тоот албан бичигт дурдсанаар;

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХЭРЭГЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

Судалгааны код: СТ-13/501

Судалгааны төрөл: Дүн шинжилгээ

Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Мягмарцэрэн, Ц.Болормаа, Д.Байгалмаа, Г.Гэрэл Ч.Онончимэг

Захиалагч: УИХ-ын гишүүн М.Батчимэг

Огноо: 2013.01.17

Сэдвийн агуулга: Энэхүү судалгаа нь дүн шинжилгээний болон судалгааны хэсгүүдээс бүрдэнэ. Судалгаанд эдийн засгийн байдлын тухай ойлголт түүний судлагдсан байдал, эдийн засгийн аюулгүй байдлын үзүүлэлтүүд, түүний үнэлгээний индикаторууд, Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлын өнөөгийн байдал, эдийн засгийн аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлүүдийг судалсан болно.

Мөн түүнчлэн УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”- д тусгагдсан Эдийн засгийн олон тулгуурт бүтцийг бий болгох зорилт, Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого, төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдлын эрсдэл, эрчим хүч, эрдэс баялгын салбарын бодлого, гадаад худалдаа, интеграцийн бодлогын хэрэгжилт эрсдэлийн өнөөгийн байдлыг статистик мэдээлэлд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн.

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Судалгааны код: СТ-13/502

Судалгааны төрөл: Дүн шинжилгээ

Гүйцэтгэсэн судлаач: Ө.Мөнхтунгалаг

Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат

Огноо: 2013.02.06

Сэдвийн агуулга: Агаарын бохирдлыг бууруулах, түүнчлэн Улаанбаатар хотыг утаагүй болгох чиглэлээр авч хэрэгжүүлсэн болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн үр дүн, зарцуулсан хөрөнгөнд дүн шинжилгээ хийж, агаарын бохирдлоос үүдэлтэй хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй өвчлөл, нас баралтыг статистик тоон үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийсэн.

ЗАРИМ ОРНУУДЫН НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН БА ЦАЛИНГИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭНИЙ ХАРЬЦАА, ХАРИЛЦАН ХАМААРЛЫН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны код: СТ-13/503

Судалгааны төрөл: Дүн шинжилгээ

Гүйцэтгэсэн судлаач: Ц.Норовдондог, Д.Мягмарцэрэн, Г.Гэрэл, Ч.Онончимэг

Захиалагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг

Огноо: 2013.02.22

Сэдвийн агуулга: Судалгаанд дэлхийн 72 орны эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох ДНБ болон цалин хөлсний дундаж үзүүлэлтийн талаарх лавлагаа мэдээлэл гаргаснаас гадна хөгжлийн түвшингээр ялгаатай 18 орныг сонгон эдгээр үзүүлэлтүүдийн хоорондын харьцаа, уялдааг холбоог эдийн засгийн эконометрик шинжилгээний аргаар тооцоолж, уялдаа холбоог авч үзэн дүн шинжилгээ хийсэн.

ЗАСГИЙН ГАЗРЫН ТҮВШИН ДЭХ ШИЙДВЭР ГАРГАЛТЫН “ЗАМЫН ЗУРАГ”, ЗАРЦУУЛЖ БУЙ ХУГАЦААНЫ ТАЛААРХ СУДАЛГАА

Судалгааны код: СТ-13/504

Судалгааны төрөл: Дүн шинжилгээ

Гүйцэтгэсэн судлаач: Р.Хатанбаатар, А.Пагма, Р.Оргилмаа

Захиалагч: УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл

Огноо: 2013.06.03.

Сэдвийн агуулга: Засгийн газраас тогтоол, шийдвэр гаргах процессийн эрх зүйн орчин, мөрдөгдөж буй дүрэм, журмын талаархи мэдээлэл лавлагаа гаргах, шийдвэрийг Засгийн газраар эцэслэн гаргах хүртэлх шат, дамжлагууд болон дамжлага бүр дээр зарцуулагдаж байгаа хугацааг тодорхой асуудлын жишээн дээр судлах, Засгийн газрын “засаглалын технологийн” өнөөгийн үйлчилж байгаа “замын зураг”-ыг тодорхойлон гаргасан.